

ӨМНӨГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН 2018 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

2018.07.01

Даланзадгад сум

Монгол Улсын Ерөнхий аудитор 2018 оныг “Аудитын үр дүн, чанарыг дээшлүүлэх” жил болгон зарласаны хүрээнд Өмнөговь аймаг дахь Төрийн аудитын газраас 2018 оныг “Аудитын үр дүн, чанарыг дээшлүүлэх, ажилчдын сахилга хариуцлагыг дээшлүүлэх” зорилт дэвшүүлэн ажиллаж байна.

Нэг. Удирдлага зохион байгуулалтын талаар

Өмнөговь аймгийн Төрийн аудитын газар нь МУЕА-ын 2017 оны 04 дүгээр сарын 20-ны өдрийн А/69 дугаар тушаалаар батлагдсан бүтэц орон тооны дагуу нийт 11 орон тоогоор ажиллахаас хагас жилийн байдлаар 8 орон тоотойгоор үйл ажиллагаагаа явуулж.Үүнд:

- дарга бөгөөд тэргүүлэх аудитор-1
- хэлтсийн дарга бөгөөд аудитын менежер-1
- ахлах аудитор-1
- аудитор, бусад ажилтан-5

Гэрээт ажилтан, нягтлан бодогч, бичиг хэргийн ажилтнууд хөдөлмөрийн гэрээ болон ажил гүйцэтгэх гэрээгээр ажиллаж байна.

Ажиллагсадын 80 хувь буюу 8 ажилтан нягтлан бодогч эдийн засагч мэргэжилтэй, 50 хувь буюу 5 ажилтан Монгол улсын мэргэшсэн нягтлан бодогч байна. Тайлант хугацаанд 3 ажилтан шинээр ажилд орж, 1 ажилтан гадаадад магистрантурт сурахаар, 1 ажилтан өөрийн хүсэлтээр ажлаас чөлөөлөгдөж, 1 ажилтан тэтгэвэрт гарсан байна.

Сүүлийн хагас жилд сул байгаа орон тоонд мэдлэг ур чадварын хувьд нийцсэн, төрийн аудитын байгууллагад ажиллах шаардлагыг хангасан хүнийг шалгаруулж авахаар төлөвлөж байна.

Хоёр. Санхүүгийн тайлангийн аудит

Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2014 оны 203 дугаар тушаалаар батлагдсан “Санхүүгийн тайлангийн аудитын журам”-ын дагуу шинээр батлагдсан бодлого, арга зүйг баримтлан Санхүүгийн тайлангийн аудитын удирдлагын систем


/СТАУС/ программыг 2018 оны санхүүгийн тайлангийн аудитад бүрэн ашиглаж, аудитын үе шат бүрт чанарын хяналтыг хэрэгжүүллээ.

2018 оны санхүүгийн тайланд төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлан 1, төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлан 15, төсвийн шууд захирагчийн санхүүгийн тайлан 78, тусгай сан 38, тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллага 81, орон нутгийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгж 42, нийт 255 байгууллага хамрагдсан.



Үүнээс түүвэрт хамрагдах 67, төрийн аудитын газар 96 байгууллага буюу 63,9 хувь, гэрээгээр Юнистар аудит ХХК нь 1, Гэрэлтэх бүртгэл аудит ХХК -нь 67 байгууллага буюу 26,7 хувийг тус тус гүйцэтгэж 9,4 хувь буюу 24 байгууллагад итгэл үзүүлж ажиллалаа.

Графикаар харуулбал:




2018 оны санхүүгийн тайлан баталгаажуулах аудитаар:

- Зөрчилгүй санал дүгнэлт 160 байгууллага
- Хязгаарлалттай санал дүгнэлт 4 байгууллага
- Санал дүгнэлт өгөхөөс татгалзсан байгууллага байхгүй нийт 164 байгууллагад дүгнэлт өгч ажилласан.


Байгууллагуудын санхүүгийн аудитын дүгнэлтийг ҮАГ-ын Санхүүгийн аудитын газарт болон байгууллагуудын төсөв захирагч нарт хуулийн хугацаанд хүргүүлсэн.

Дүгнэлт өгсөн байдлыг графикаар харуулбал:



Аудитаар нийт 19,351.9 сая төгрөгийн алдаа зөрчил илрүүлж 18,519.0 сая төгрөгийн алдааг аудитын явцад залруулав. Санхүү, төсвийн үйл ажиллагааг сайжруулах зорилгоор 144 заалт бүхий 76 байгууллагад менежментийн захидал хүргүүлэв.

Аудитаар илэрсэн алдаа, дутагдал, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар нийт алдааны 1.9 хувь буюу 382,4 сая төгрөгийн зөрчилд, төсвийн зарчмыг зөрчсөн төсвийн 4 шууд захирагчид хариуцлага тооцуулах албан шаардлага хүргүүлж, төсвийн хөрөнгийн зориулалтыг зөрчиж зүй бусаар зарцуулсан, хууль тогтоомж зөрчсөн зөрчлийг арилгахаар 28.5 сая төгрөгийн төлбөрийн акт тогтоож ажиллалаа.



Тайлант оны эхний хагас жилд 27,8 сая төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлж, актын барагдуулалт 96,8 хувь, албан шаардлагын хэрэгжилт 37,5 хувь, зөвлөмжийн хэрэгжилтийг 16,6 хувь хангуулан ажиллалаа.

Санхүүгийн тайлангийн аудитаар нийтлэг гарсан зөрчлүүд:

- НБББББичиг: Монгол Улсын Засгийн газрын 2014 оны 09 дүгээр сарын 18-ны өдрийн 297 тоот тогтоолын дагуу Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг шинэчлэн боловсруулж, батлуулж мөрдөөгүй.
- Санхүүгийн тайлангийн тодруулга тайлан бэлтгээгүй нь үнэлгээ, толилуулга ба тодруулга, үнэн зөв байдал гэсэн мэдэгдлүүдийн шаардлагыг хангахгүй байна.
- Худалдаж авсан үндсэн хөрөнгийг мөнгөн гүйлгээний хөрөнгийн зардлаар бүртгээгүй, зардлын эдийн засгийн ангилалыг хольж бүртгэсэн.
- Цалин, нийгмийн даатгалын шимтгэл, шатахуун, бараа материалын зардлуудын эдийн засгийн ангилалыг хольж бүртгэсэн.
- Сангийн сайдын 2016 оны 11 дүгээр сарын 27-ны өдрийн 388 тушаалаар батлагдсан “Төсөвт байгууллагад мөрдөх дансны заавар”-ыг бүрэн мөрдөж ажиллаагүй.
- Урсгал зардлаас үндсэн хөрөнгө бэлтгэсэн нь Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.24 дэх заалтыг хэрэгжүүлж ажиллаагүй.
- Засаг даргын нөөц сангаас хоолны үнэ, буудлын төлбөр зэрэг зардлуудыг зориулалт бус зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.2 заалтыг зөрчсөн байна.

- 2016 оны жилийн эцсийн авлагыг бууруулсан хэдий ч тооцоо нийлсэн акт байхгүй бүртгэсэн нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.4 дэх заалтыг тус тус хэрэгжүүлээгүй байна.
- Байгууллагууд өр, авлага үүсгэж ажиллаж байна. Энэ нь “Төсвийн тухай хууль”-ийн 6 дугаар зүйлийн 6.4.8 /төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх/-дах заалтыг зөрчиж байна.
- Тайлант онд үндсэн хөрөнгө балансаас балансад шилжүүлж орлого үр дүнгийн тайлангийн элэгдэлийн зардлыг нэмэгдүүлэн бүртгэсэн нь УСНББОУС-17-д заасан "үндсэн хөрөнгийг хүлээн авч, бүртгэлд тусгахдаа бодит үнэ цэнээр бүртгэнэ" гэсэн заалттай нийцэхгүй байна.
- Төсвийн гүйцэтгэлийн тайланд тохируулах бичилтийг зөрүүтэй тайлагнасан нь Сангийн сайдын 2012 оны 76 дугаар "Төсвийн гүйцэтгэлийн тайлан боловсруулах журам"-ын 2 дугаар зүйлийн 2 дахь заалтыг хэрэгжүүлж ажиллаагүй байна
- Сум хөгжүүлэх сангийн холбогдох албан тушаалтнууд авлагын тооцоог тухай бүр хийж барагдуулах талаар тодорхой арга хэмжээ авахгүй, санал санаачлага гаргахгүй байгаагаас авлага он дамжиж, насжилт нэмэгдэн улмаар төлөгдөх найдваргүй болох нөхцөл байдал үүсч болзошгүй байна.
- Орон нутгийн төсвийн орлогын төлөвлөгөөнд шууд бус орлого 181.4 сая төгрөг, түрээсийн орлого 6.8 сая төгрөгөөр төсөвлөсөн боловч гүйцэтгэлээр шууд бус орлого 453.9 сая төгрөг, түрээсийн орлого 44.2 сая төгрөг төвлөрч 250.1-650.2 хувиар давуулан биелүүлсэн. Иймд шууд бус орлогоор тайлагнаж буй сумдын татварын орлого, түрээсийн орлогыг бодитой төлөвлөх шаардлагатай байна.
- Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд 43 орон нутгийн өмчит хуулийн этгээдийн санхүүгийн тайлан нэгтгэсэн ба үүнээс 22 байгууллага 1,122.8 сая төгрөгийн алдагдалтай ажиллаж байна.
- ОНӨААТҮГазрууд үнэ төлбөргүй хүлээж авсан үндсэн хөрөнгийн дүнгээр эздийн өмч данс өсгөж бүртгэсэн байна.
- УИХурлын 67 дугаар тогтоолын дагуу урамшуулал олгохдоо сахилгын шийтгэлтэй хүнд олгосон зэрэг зөрчлүүд гарч байлаа.

Нийт санхүүгийн тайлангаас илэрсэн алдаа зөрчлийн 82,0 хувь буюу 15,892.7 сая төгрөгийг төсөвт байгууллагууд, 17,9 хувь буюу 3,480.0 сая төгрөгийг орон нутгийн өмчийн аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар, 0,1 хувийн алдааг төсөл сан эзлэж байна.

Санхүүгийн тайлан баталгаажуулах аудитын үйлчилгээний төлбөрт 23,6 сая төгрөгийн гэрээ байгуулж, 18,8 сая төгрөгийн аудитын төлбөрийг орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн нь 79,6 хувиар биелүүлсэн бөгөөд 3-р улиралд багтаан бүрэн төвлөрүүлж дуусгаж ажиллахаар төлөвлөж байна.

Гурав. Гүйцэтгэлийн аудит

2018 оны эхний хагас жилд Үндэсний аудитын газрын нэгдсэн төлөвлөгөө, хөтөлбөрөөр 3 аудитыг хийж гүйцэтгэлээ. Аудитаар нийт 7,125.0 сая төгрөгийн алдаа зөрчил илрүүлж, 3 албан шаардлага хүргүүлж ажиллалаа.

1. “Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2010-2017 онуудад хэрэгжсэн дуусаагүй орхигдсон барилга байгууламж”-д хийсэн аудитын талаар:

Аудитыг 2018 оны 01 дугаар сарын 02-оос эхлэн 03 дугаар сарын 20-ны өдөр хүртэл хугацаанд ажлын 51 хүн/өдөр зарцуулан гүйцэтгэлээ. Аудитад улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2010-2017 онуудад хэрэгжиж дуусаагүй орхигдсон Манлай, Ноён, Номгон сумдын соёлын төвийн барилга, Даланзадгад суманд баригдаж байгаа барилгын материалын лабораторийн барилгууд хамрагдлаа. Дээрх барилгуудын талаарх дэлгэрэнгүй мэдээллийг батлагдаж ирсэн маягтын дагуу гаргаж бусад холбогдох мэдээллийг ГАГ-т хүргүүлж ажиллалаа. Мөн ГАГ-аас томилогдож ирсэн шинжээч нар газар дээрх байдалтай танилцан хэмжилт, дээж авах зэрэг ажлуудыг хийж гүйцэтгэсэн.

2. “Улсын төсвийн 2017 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт үр дүн, үр ашиг”-т хийсэн аудитын талаар:

Аудитыг 2018 оны 01 дүгээр сарын 02-оос эхлэн 04 дүгээр сарын 20-ны өдрийг хүртэл хугацаанд ажлын 79 хүн өдөр зарцуулан гүйцэтгэлээ. Аудитад улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2017 онд эрх шилжиж ирсэн 8 их засварын ажил хамрагдлаа. Их засварын ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерийн үйл ажиллагаа хууль журмын дагуу явагдсан эсэх санхүүжилтийг ажлын гүйцэтгэлийн харгалзан үнэн зөв олгосон зэрэг асуудлуудыг шалгалаа. Аудитын явцад засварын ажлын гүйцэтгэл, байгууллагын санал дүгнэлттэй танилцахад ашиглалтын явцад зөрчил илрээгүй. Аудитаас албан шаардлага, төлбөрийн акт, зөвлөмж өгөгдөөгүй болно.

Дөрөв. Нийцлийн аудит

Нэгдсэн төлөвлөгөө хөтөлбөрийн дагуу хөтөлбөрийн дагуу нийцлийн аудит эхний хагас жилд байхгүй байна.

1. 2016 оны ээлжит сонгуулиар суудал авсан намын мөрийн хөтөлбөрийн хэрэгжилтийн дүнг 1 дүгээр улиралд явуулах МҮЕА-н орлогчын 2018 оны 02 сарын 12 өдрийн 01/349 дугаар албан бичгийн дагуу МАН-н ирүүлсэн мөрийн хөтөлбөрийн хэрэгжилтийг тооцож 03 дугаар сарын 22-нд хүргүүлж ажиллалаа.

АИТХ-д суудал авсан МАН, АН-д мөрийн хөтөлбөрийн хэрэгжилтийг ирүүлэх албан бичиг хүргүүлсэн боловч АН-аас хариу албан бичиг ирээгүй болно.

Тав. Аймгийн ИТХ-ын захиалгаар хийсэн аудит

Нэгдсэн төлөвлөгөөнд тусгагдсан дагуу орон нутгийн өмчит Таван толгой ХК-ны 2009-2016 оны үйл ажиллагааны үр дүнд гүйцэтгэлийн аудит хийгдэж байна. Аудитын төлөвлөлтийн үе шатны ажлыг 2018 оны 04 дүгээр сарын 27-ны өдрөөс эхлэн 05 дугаар сарын 18-ны өдөр хүртэл ажлын 16 хоногт, талбарын ажлыг 2018 оны 05 дугаар сарын 21-ны өдрөөс 06 дугаар сарын 29-ны өдөр хүртэл ажлын 25 хоногт, тайлагналын үе шатны ажлыг 07 дугаар сарын 02-ны өдрөөс 10-ны өдөр хүртэл ажлын 7 хоногт дуусгаж, 07 дугаар сарын 16-аас 07 дугаар сарын 18-ны хооронд Монгол Улсын Ерөнхий аудиторт танилцуулж, 2018 оны 07 дугаар сарын 23-ны өдрийн дотор Тэргүүлэх аудиторын тушаалаар баталгаажуулан Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд хүргүүлэхээр ажиллаж байна.

Зургаа. Дотоод ажлын талаар

2018 онд хэрэгжүүлэх байгууллагын үйл ажиллагааны төлөвлөгөө, авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлэх үйл ажиллагааны дэд төлөвлөгөөнүүдийг боловсруулан батлуулж мөрдлөг болгон ажиллаж байна. Мөн албан тушаалтнуудын хувийн ашиг сонирхолын болон хөрөнгө орлогын мэдүүлгийг гаргуулан хуулийн хугацаанд ҮАГ-т хүргүүлсэн.

Дарга бөгөөд тэргүүлэх аудитор Монгол Улсын Ерөнхий аудитортой байгуулсан үр дүнгийн гэрээний дагуу өөрийн аудиторуудтайгаа үр дүнгийн гэрээг байгуулан баталгаажуулж хагас жилээр гэрээний хэрэгжилтийг гаргуулан дүгнэж ажиллалаа. Гэрээний хэрэгжилт дүгнэсэн байдлыг ҮАГ-т хүргүүлсэн болно.

Аудиторуудын гүйцэтгэж буй аудит тус бүр дээр Ашиг сонирхолын зөрчилгүй тухай мэдэгдэл гаргуулан авахын зэрэгцээ төрийн аудиторуудын ёс зүйн дүрмийг чандлан сахиж, мөрдөж ажиллах тухай, төрийн нууцын баталгаа гаргуулан Монгол

Улсын Ерөнхий аудиторын 2003 оны 02 дугаар тушаалаар батлагдаж 2013 оны 131 дугаар тушаалаар нэмэлт өөрчлөлт оруулсан “Төрийн аудитын байгууллагын ажилтны ёс зүйн дүрэм”-ийг уншиж танилцуулан сонсгол хийн байгууллагын дотоод сахилга хариуцлагыг дээшлүүлэх талаар анхаарч ажиллалаа.

Төрийн аудитын байгууллагын удирдах ажилтны зөвлөгөөнд тэргүүлэх аудитор хамрагдан зөвлөгөөнд ярилцаж хэлэлцсэн асуудлуудыг танилцуулан 2017 ажлын үр дүнг хэлэлцэн, 2018 оны ажлын гүйцэтгэлд анхаарах асуудлуудыг дотоод хурлаар хэлэлцэж үүрэг даалгавар өгч ажиллалаа.

Төрийн аудитын байгууллагын 2018 оны сургалтын нэгдсэн төлөвлөгөөний хүрээнд зохион байгуулсан “Төрийн аудитын байгууллагын шинэ ажилтны сургалт”-д 2017 болон 2018 онуудад шинээр орсон 3 аудиторуудыг хамруулан арга зүй, мэдлэг чадварыг дээшлүүлэх талд анхаарч ажиллалаа.

2018 онд нийт ажилчдынхаа эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгийг нэгдүгээр улиралд зохион байгуулан аймгийн бүсийн оношлогоо эмчилгээний төвд бүрэн шинжилгээ, үзлэг оношлогоонд хамруулан эрүүлжүүлэх талаар онцгой анхаарлаа.

Үндэсний аудитын газраас Улсын Их Хурлын Төсвийн Байнгын хорооны 2017 оны 06 дугаар тогтоол, Монгол Улсын Ерөнхий аудиторт Үндэсний аудитын газраас 2018 онд нийлүүлэх аудитын болон ажил, үйлчилгээний төлөвлөгөөний дагуу Өмнөговь аймгийн орон нутгийн өмчит “Таван толгой ХК-ийн 2009-2016 оны үйл ажиллагааны үр дүн”-д гүйцэтгэлийн аудит хийх баг бүрэлдэхүүнийг мэргэжил, арга зүйн зөвлөгөө авах ажлаар ҮАГ-т 3 хоногийн дагалдан сургалтад хамрууллаа.

Сүлжээний аюулгүй байдал, найдвартай байдлыг хангах ажлыг зохион байгуулж засвар, үйлчилгээний ажлыг хийж гүйцэтгэн дотооддоо “Мэдээллийн технологийн аюулгүй байдал”, “Хараат бус хуулийн этгээдийн хийсэн санхүүгийн тайлангийн аудитын ажлыг гүйцэтгэлийг үнэлэх аргачлал”, “Шри шри бясалгал”, “Төрийн албаны нууцын тухай”, “Албан хэрэг хөтлөлт” зэрэг сэдвээр сургалт зохион байгууллаа.

Аймгийн Санхүү төрийн сангийн хэлтэстэй хамтран санхүүгийн тайлангийн аудитын баталгаажуулалтын талаар хамтарсан хэлэлцүүлэг зохион байгуулсан байна.

“Төрийн албаны манлайлыг хангах нь” сэдэвт сургалтыг Монгол Улсын Их Хурлын гишүүн Н.Амарзаяа, УИХ-н тамгын газар, Засгийн газрын хэрэг эрхлэх газар, Төрийн албаны зөвлөл, Удирдлагын академи, МУИС, аймгийн Тамгын газартай хамтран зохион байгуулсан сургалтад байгууллагын нийт ажилчид хамрагдлаа.

Аймгийн төсөв, санхүүгийн байгууллагуудын удирдах ажилтны зөвлөгөөнд нийт албан хаагчид хамрагдан тэргүүлэх аудитор илтгэл мэдээлэл хийлээ.

Даланзадгад сумын харьяа төсөвт байгууллагуудын хамтын үйл ажиллагааг сайжруулах, төсвийн сахилга хариуцлагыг дээшлүүлэх, ажлын үр дүнг сайжруулахад чиглэсэн “Сахилга хариуцлагыг дээшлүүлэх нь” сургалтад 2017 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлт, цаашид анхаарах арга хэмжээний талаар тэргүүлэх аудитор илтгэл тавьж оролцлоо.

ҮАГ-ын ГА-н газраас Гурвантэс суманд байрлах 5 уурхайн Стратегийн орд газрын эзэмшигчдийн ЗГ-ын өмнө хүлээсэн үүргийн хэрэгжилт аудитаар ирсэн багтай хамтран албан томилолтоор 7 хоног хамтран ажиллалаа.

Олон улсын эмэгтэйчүүдийн өдрийг тохиолдуулан нийт эмэгтэй ажилчдыг хамруулан “Цэргийн нэг өдөр” арга хэмжээг аймгийн завсэгт хүчний 0167 дугаар ангитай хамтран нэг өдрийн үйл ажиллагааг зохион байгууллаа. Мөн сар шинийн баяр, ахмадын баяр, олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдрийг тохиолдуулан хүүхэд, ахмадуудад хүндэтгэл үзүүлэн гарын бэлэг гардууллаа.

Үндэсний мод тарих өдрийн хүрээнд аймгийнхаа цэнгэлдэх хүрээлэнд байгууллагын нэрийн өмнөөс 20 ширхэг мод суулган төрийн аудитын байгууллагын үүрэг хариуцлагыг ухамсарласан үйл ажиллагаанд хамтран оролцлоо. Хувь хүний болон айл өрхийн аюулгүй аж төрөх нөхцөлийг хангуулах үүднээс Аймгийн онцгой байдлын газраас хэрхэн эрүүл аюулгүй амьдрах талаар сургалт авч ажилчдыг бүрэн хамрууллаа.

Хүний нөөцийн бодлогын хүрээнд гадаадад суралцахаар явсан, тэтгэвэрт гарч байгаа аудитор, жолооч гэсэн гурван ажилтны сул орон тоог нөхөх үүднээс МУЕА-н тушаалаар ажил гүйцэтгэх гэрээ байгуулан 1 аудитор, хөдөлмөрийн гэрээгээр 1 жолооч, үр дүнгийн гэрээ байгуулан 1 аудиторыг тус тус сонгон шалгаруулж авлаа.

Иргэд олон нийттэй харилцах, мэдээлэл солилцох зорилгоор audit.mn цахим хуудас, байгууллагын facebook хуудсаар дамжуулан давхардсан тоогоор нийт 14 удаа мэдээлэл нийтэлж, аудиттай холбоотой болон шилэн дансны цахим хуудсанд төсөв, санхүүтэй холбоотой мэдээллийг хуулийн хугацаанд тогтмол байршуулж ажиллалаа.

Байгууллагын дарга, тэргүүлэх аудиторын тушаал 13, явсан бичиг 77, төлбөрийн акт 34, албан шаардлага 57 холбогдох журам, стандартын дагуу гаргаж ажилласан. Мөн байгууллагад ирсэн 335 бичиг, 8 өргөдөл ирүүлснийг хуулийн хугацаанд бүрэн шийдвэрлэн хариуг хүргүүлж ажиллалаа.

Эрүүл аюулгүй орчинд ажиллах, ажлын байрны орчин нөхцөлийг сайжруулахад анхаарч ажлын байранд хүн нэг бүр 2 ширхэг тасалгааны таримал цэцэг авчран тохижууллаа.

ҮАГ-с хүний нөөцийн менежер Ж.Дэмчигсүрэнгээр ахлуулсан баг ирж байгууллагын дотоод үйл ажиллагаа, архив, бичиг хэрэг хөтлөлтийн талаар заавар зөвлөмж өгч, сургалт явуулсаны дагуу өөрийн ажилчдын хувийн хэргийг 100% шинэчлэн баяжуулж, бичиг хэргийн хөтлөлт, хадгалалт хамгаалалтыг сайжруулан мөрдлөг болгон ажиллаж байна.

Хамт олны дотоод үйл ажиллагаатай холбоотой долоо хоног тутмын шуурхай хурлыг тогтмол зохион байгуулж тэмдэглэл хөтлөн баталгаажуулж хэвшээд байна.

Ажлын цаг бүртгэл, ажлын цаг ашиглалтыг сайжруулах үүднээс хурууны хээгээр цаг бүртгэх төхөөрөмжийг хоёрдугаар улирлаас эхлэн ашиглаж эхлээд байна.

Өмнөговь аймгийн хэмжээнд 2018 оныг “Бүтээн байгуулалтын жил” болгон зарласны хүрээнд аймгийн Татварын хэлтэс, ХХҮГ-тай хамтран аймгийн БОЭТ-д 1,5 сая төгрөгний бүтээн байгуулалтын ажлыг хийж хүлээлгэн өглөө.

Долоо. Санхүүгийн тайлагнал, төсвийн гүйцэтгэлийн талаар

Төрийн аудитын газрын 2017 оны санхүүгийн тайланг стандартын дагуу үнэн зөв гарган хуулийн хугацаанд “Улаанбаатар аудит корпораци” ХХК-аар аудит хийлгэж “Зөрчилгүй” санал дүгнэлт авсан.

УСНББОУС болон шинээр гарсан хууль тогтоомжийг нягтлан бодох бүртгэл, санхүүгийн үйл ажиллагаандаа мөрдөж, төсвийн гүйцэтгэлийн мэдээг сар бүр Аймгийн санхүү, төрийн сангийн хэлтэс болон ҮАГ-т мэдээлж, улирал бүр Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар аргачлалын дагуу ”СИ ТИ ЭС” программаар санхүүгийн тайлан бэлтгэн гаргаж, Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2018 оны 5 дугаар сарын 30-ны өдрийн 02/1248 дугаар албан бичгээр хүргүүлсэн 2018 оны шинэ сар улирлын хуваарийн дагуу баталгаажуулан батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргаж, төсвийг хэмнэлттэй зарцуулж ажиллалаа.

Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2018 оны 4 дүгээр сарын 16-ны өдрийн а/69 дугаар тушаал, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын даргын 2018 оны 3 дугаар сарын 6-ны өдрийн 57 дугаар тогтоолыг тус тус үндэслэн нийт 3,7 сая төгрөгийн тоног төхөөрөмжийг үндсэн хөрөнгөд бүртгэн өөрийн хөрөнгөөр бэлтгэж бүртгэлд тусгаж ажиллалаа

Шилэн дансны тухай хууль, МУ-ын ЗГ-ын 2016 оны 29 дүгээр тогтоолыг хэрэгжүүлэн төсвийн ил тод байдлыг ханган жил, хагас жил, улирал, сар тухай бүр оруулах мэдээллийг үнэн зөв хуулийн хугацаанд нь шилэн дансны цахим хуудас болон мэдээллийн самбарт байршуулан ажиллалаа.

2018 онд шинээр батлагдсан Албан ажлын онцгой нөхцөлийн нэмэгдэл, Төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл зэргийг тус тус тушаалийн шийдвэрийн дагуу хугацаанд нь олгож мөрдөж ажиллаж байна.

Мөн 2019 оны төсвийн төслийг төсвийн суурь зарлага тооцох аргачлалын дагуу Төсвийн тухай, Хөдөлмөрийн тухай, Төрийн албаны тухай, Төрийн аудитын тухай хууль болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан хууль эрх зүйн хүчин төгөлдөр актууд, байгууллагын дотоод журмыг тус тус удирдлага болгон өмнөх онуудын төсвийн гүйцэтгэл, холбогдох тооцоо судалгаанд суурилан боловсруулж баталгаажуулан ҮАГ-ын холбогдох мэргэжилтэнд хугацаанд цахимаар хугацаанд нь хүргүүлж ажиллалаа.

ҮАГГазар болон аймгийн Санхүү төрийн сангийн хэлтсээс ирүүлсэн судалгаа бусад мэдээллийг хугацаанд нь үнэн зөв гаргаж, хүргүүлэн төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг холбогдох хууль тогтоомж стандартын дагуу хөтлөн явуулж ажиллалаа.

Өмнөговь аймаг дахь Төрийн аудитын газар нь 2018 оны 6 дугаар сарын 30-ны байдлаар нийт 142,5 сая төгрөгийн төсөв зарцуулахаас гүйцэтгэлээр 142,8 сая төгрөгийг холбогдох зардалд зориулалтын дагуу зарцуулж, нийт 51,2 сая төгрөгийн төсөв хэмнэн, өр авлагагүй ажиллаж байна.

Найм. Дүгнэлт

Манай хамт олон Монгол улсын Ерөнхий аудитор, аймгийн Төрийн аудитын газраас дэвшүүлсэн зорилтын хүрээнд байгууллагын 2018 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулан, эхний хагас жилд гүйцэтгэхээр төлөвлөсөн ажлыг бүрэн хэрэгжүүлэн ажиллаж байна.

Тайлант хугацаанд үйл ажиллагаандаа АДБОУС, Аудитын Олон улсын стандартыг мөрдөн Төрийн аудитын тухай хуулинд заасан бүрэн эрхээ хэрэгжүүлэхдээ хууль дээдлэх, шударга ёсыг хангах, ил тод бодитой байх, төрийн аудитын нийтээр зөвшөөрөгдсөн зарчим, стандартад нийцсэн байх үндсэн зарчмуудыг баримтлан, ёс зүйн хэм, хэмжээг сахиж, ашиг сонирхолын зөрчилгүй шударга ажиллалаа.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

П.АЛТАНЗАЯА